

Ерөнхийлөгч
Дийтр Ф.Угдорф

Тэргүүн Зөвлөлийн
хоёрдугаар зөвлөх



Амьдралын бүхий л цаг мөч дэх гэгээнтнүүд

Жилийн дөрвөн улирал солигдож байгааг харуулсан зурагтай ил захидал мэт дэлхийн нэгээхэн хэсгийн талаарх хүүхэд насны минь дурсамж надад байдаг. Өнгөрөн улирах сар болгон ер бусын мөн гайхамшигтай байдаг байлаа. Өвлийн төгс сайхан өдөр хотын гудамжууд болон уул нурууг цэвэрхэн цас бүрхсэн байдаг. Хаврын бороо бүхий л зүйлийг цэвэрлэн, мод, ургамал, цэцэгс нахиалж дэлбээнэ. Зуны улирлын тайван тогтуун цэнхэр тэнгэрийг хурц нар гэрэлтүүлдэг байв. Гайхамшигтай намрын улирал байгалийг улбар шар, шар, мөн улаан өнгөтэй болгон өөрчилдөг. Хүүхэд байхдаа, би улирал бүрт дуртай байлаа. Одоо ч гэсэн би улирал нэг бүрийн шинж чанар, өвөрмөц байдалд дуртай.

Бидний амьдралд ч бас цаг хугацаа буюу улирлууд байдаг юм. Зарим нь урьхан зөөлөн мөн тааламжтай сайхан байхад зарим нь тийм биш байдаг. Бидний амьдралын зарим өдрүүд хуанлийн зурагтай адил тийм сайхан байдаг. Гэвч зарим өдрүүд болон амьдралын нөхцөл байдлууд нь сэтгэлийн шаналлыг бий болгож бидний амьдралд асар их цөхрөл бухимдал, гомдол хорслыг авчирдаг.

Зөвхөн зурган дээр байдаг шиг тийм төгс өдрүүдэд амьдарч байх зуурт тохиолддог таагүй цаг

мөчүүдээс зайлсхийж амьдрахсан гэсэн бодол бид бүгдэд хэзээ нэгэн цагт төрж байсан нь гарцаагүй.

Гэвч энэ нь боломжгүй бөгөөд хүслийн дагуу болдог зүйл биш юм.

Би амьдралаа эргэн харахад, зовж зүдэрч байсан тэр л цаг мөчүүдэд би хамгийн ихээр өсч хөгжсөн нь тодорхой байсан билээ.

Бүхнийг мэддэг Тэнгэрлэг Эцэг маань Өөрийн хүүхдүүд нь төлөвлөгөөний дагуу өсч хөгжихийн тулд өөрсдийн мөнх бус амьдралдаа бэрхшээлт цаг үеүдийг даван туулах хэрэгтэй гэдгийг мэдэж байсан. Мормоны номын бошиглогч Лихай хэлэхдээ сөрөг талгүйгээр: “зөв шударга нь тохиохгүй болой” (2 Нифай 2:11) хэмээжээ. Үнэндээ зовлон зүдгүүр нь бидэнд амьдралыг таньж мэдэн, түүний талаар эргэцүүлэн бодож үзсэнээр л түүний амар амгалан байдалд талархах боломжийг бидэнд олгодог. (С ба Г 29:39; Мосе 6:55-ийг үз).

Ерөнхийлөгч Бригам Янг энэ талаар “Алдар суу, үхэшгүй байдал, мөн мөнхийн амьдралын титмээр өргөмжлөгдсөн бүхий л ухаалаг хүмүүс өөрсдийн алдар суу мөн өргөмжлөлийг олж авахын тулд ухаалаг хүн бүрт тохиолддог хүнд хэцүү сорилт болгоныг даван туулах ёстой байдаг. Хүмүүнд тохиолдох зовлон зүдгүүр нь . . . тэднийг Их Эзэний оршихуйд

ороход нь бэлтгэх болно. Та нарын даван туулж байгаа сорилт, туршлага бүр нь та нарын авралд хэрэгтэй юм”¹ гэж хэлсэн.

Асуулт нь бэрхшээлүүдтэй тулгарах уу үгүй юу гэдэгтээ бус харин бид уг бэрхшээлүүдийг хэрхэн, яаж даван туулах вэ гэдэг нь л чухал юм. Амьдралын цаг мөчүүд байнга хувьсан өөрчлөгдөж байгаа энэ цаг үед Бурханы итгэмжит үгнээс зууран барих нь бидний хувьд агуу их боломж юм. Амьдралын хэцүү цаг үед биднийг үгээр хэлэхийн аргагүй баяр баясгалан ба мөнхийн амьдралын гайхамшигтай гэрэл рүү удирдан хөтлөх үнэтэй сайхан мэдлэгийн талаарх Өөрийн үгийг Тэнгэрлэг Эцэг Өөрийн бошиглогчдоор дамжуулан өгсөн билээ. Бидний амьдралд тохиолдож болох хэцүү байдлуудыг үл харгалзан үнэн болон шулуун шударга байдлаас зууран барих тэрхүү хүч чадал, урам зориг, мөн шударга байдлыг хөгжүүлэх нь амьдралын маань чухал хэсэг болдог.

Баптисм хүртэн мөн Ариун Сүнсний бэлгийг хүлээн авсан хүмүүс шавь болж явах зам дээрээ хөлөө тавьсан бөгөөд Аврагчийн жишээг итгэлтэйгээр мөн тууштай дагах үүрэг хариуцлага хүлээсэн байдаг.

Нар бол “муу муухай зүйл мөн сайн сайхан зүйл дээр ч тусдаг . . . шударга мөн шударга бус зүйл дээр ч бороо [ордог]” хэмээн Аврагч заасан (Матай 5:45). Заримдаа бид амьдралд яагаад хэцүү тэр бүү хэл шударга бус зүйлс тохиолддогийг ойлгож чаддаггүй. Гэвч, Христийн дагалдагчдын хувьд, хэрэв бид “хичээнгүйлэн судалж, үргэлж залбиралтай мөн итгэлтэй байвал, . . . *хэрэв* [бид] цэх шулуун алхах юм бол [бидний] сайн сайхны тулд бүх зүйл хамтдаа ажиллах болно” гэдэгт итгэдэг. (С ба Г 90:24); тодотгол нэмсэн.

Түүний Сүмийн гишүүд ба Гэгээнтнүүд болохын хувьд дөрвөн улирлын турш болон ямар ч цаг агаарын нөхцөлд бид баяртайгаар мөн сайн дураараа үйлчилдэг. Бид ийн үйлдсэнээр зүрх сэтгэл маань ариун нандин итгэл, эдгээгдэх найдвар, тэнгэрлэг энэрлээр дүүрэн болдог юм.

Гэсэн ч бид таатай сайхан мөн хэцүү бэрхшээлтэй цаг үеүдийн аль алийг нь туулах ёстой. Гэхдээ ямар ч цаг улиралд Есүс Христийн дагалдагчдын хувьд Түүний гэрэл гэгээ рүү алхан явахдаа бид Түүнд өөрсдийн найдварыг тавьдаг билээ.

Дүгнэн хэлэхэд бид Түүний тухай сурах, Түүнийг болон бусад хүмүүсийг хайрлахаар шийдсэн Бурханы Гэгээнтнүүд юм. Бид Түүний шавь байхаар адислагдсан замаар явж байгаа аялагчид бөгөөд өөрсдийн тэнгэрлэг зорилгод хүрэхийн төлөө тууштайгаар алхацгааж байна.

Тиймээс хавар, зун, намар, өвлийн улирал бүрт Гэгээнтэн ах, эгч нар байцгаая. Амьдралынхаа бүхий л цаг мөчид Гэгээнтнүүд байцгаая.

ЭШЛЭЛ

1. *Teachings of Presidents of the Church: Brigham Young* [1997], 261–62.

ЭНЭ ЗАХИАСААС ЗААХ НЬ

Тэргүүн Зөвлөлийн зааснаар: “Хамгийн агуу зарим нэгэн номлолууд нь дууллуудыг дуулснаар тунхаглагдсан. (*Дууллууд* ix). Та энэ захиасын талаар ярилцахдаа зааж байгаа хүмүүстэйгээ эдгээр дууллуудын аль нэгийг эсвэл бэрхшээлийг тэвчин өнгөрүүлж байгаа тухай өөр нэгэн дууг дуул: “Бат Бөх Суурь” (85), “The Lord Is My Shepherd” (no. 108); or “Let Us All Press On” (no. 243). Амьдралд тань тохиолдсон хэцүү бэрхшээлтэй цаг мөч таны хувьд адислал байсан талаар сүнсээр өдөөгдсөн үедээ хуваалц.

ӨСВӨР ҮЕИЙНХЭН

Би уй гашуугаа тайлж чадсан.

Жуан Зү

Миний найз Чен ах болон түүний эхнэр хоёр баптисм хийлгэн манай тойрогт ирэхэд би маш ихээр баярлаж билээ. Баптисм хийлгэснээс хойш жилийн дараа тэднийг Сүмд орохоос өмнө нас барсан хүүтэйгээ тэд ариун сүмд лацдан холбогдсон юм. Чений гэр бүлийг сайн мэдээнд өсөж байгааг харах нь үнэхээр гайхалтай байлаа.

Гэтэл дараа жил нь Чен ах автомашины осолд орж нас барсан юм. Энэхүү ослын дараа, түүний нас барсан талаар би үргэлж бодон зүүдэлдэг байлаа. Би нүдэндээ нулимстай сэрэхдээ “Яагаад? Их Эзэн яагаад ийм гай зовлонг хүмүүсийн амьдралд тохиолдохыг зөвшөөрдөг юм бол? Яагаад ийм зүйл энэ сайхан гэр бүлд тохиолдов?” гэж дахин дахин асууж байсан. Нэгэн өдөр, би эдгээр асуултуудын талаар бодож байхдаа нэг гарын авлагыг ширээн дээрээс

авч Ерөнхийлөгч Спенсер В.Кимбаллын (1895–1985) хэлсэн дараах үгсийг уншсан юм:

“Хэрвээ бидэнд энэ амьдралаас өөр амьдрал байхгүй хэмээн үзвэл өвчин зовлон, бүтэлгүйтэл мөн богино наслалт нь аймшигтай золгүй цөхрөл байх байсан. Гэвч бид энэ амьдрал бол өмнөх дэлхийг туулаад, үхлийн дараах мөнхийн ирээдүй рүү үргэлжилж яваа мөнхийн зүйл хэмээн ойлговол эдгээр болж байгаа бүхий л зүйлсийг зөвөөр олж харж чадах юм. . . .

“Бидний хүч чадлыг сорихын тулд уруу таталтууд, биднийг тэвчээртэй байдалд сургахын тулд өвчин эмгэг, мөн бид мөнхөрч улмаар алдаршуулагдахын тулд нас баралт бидэнд тохиолддог бус гэж үү?”¹

Би яг тэр мөчид уй гашуугаа тайлж амлагдсан ирээдүй рүү харахаар шийдэж билээ. Чен ах гэр бүлтэйгээ баяртайгаар дахин нэгдэж буйг би өөрийн оюун санаандаа харсан юм. Тэрхүү дүр төрх нь надад амар амгалан байдлыг авчирсан билээ. Тэнгэрлэг Эцэг

бидэнд бэрхшээлүүдийг сөрөн зогсож чадах зориг мөн мэргэн ухааныг өгдөг болохыг би мэднэ.

Зохиогч нь Тайвань улсаас ирсэн.

Эшлэл

1. *Сүмийн ерөнхийлөгчдийн сургаалаас: Спэнсэр В.Кимбалл* (2006), 15.

ХҮҮХДҮҮД

Дөрвөн улирлын турш үйлчлэх нь

Ерөнхийлөгч Угдорф бидэнд “Дөрвөн улирлын турш мөн цаг агаарын ямар ч нөхцөл байдалд бид баяртайгаар мөн сайн дураараа үйлчлэх ёстой” гэж заадаг. Өвлийн улиралд ямар арга замуудаар та бусдад үйлчилж болох вэ? Хаврын улиралд ямар арга замаар та бусдад үйлчилж болох вэ? Зун болон намрын улиралд юу хийж болох вэ? Улирал бүр хийж болох зүйлийнхээ талаар өөрийнхөө санаануудаас бич. Та энэ сард тэдгээр санаануудынхаа нэгийг нь хэрэгжүүлээрэй!



Итгэл, Гэр бүл, Халамж

Бие даасан байдал

Энэ материалыг залбирч судлан гэрт нь очиж заадаг эгч нартайгаа аль болох тохиромжтой хэсгийн талаар ярилц. Эгч нарыг хүчирхэгжүүлэх болон Нийгмийн Халамжийн бүлэг өөрийн тань амьдралд идэвхтэй үүрэг гүйцэтгэхэд туслах асуултуудыг асуу. Нэмэлт мэдээллийг reliefsociety.lds.org-аас үзнэ үү.

Бие даасан байдал нь чадвар, үүрэг хүлээх байдал мөн өөрсдийн болон гэр бүлийнхээ сүнслэг бөгөөд материаллаг аж байдлыг хангах хүчин чармайлт юм.¹

Бид өөрсдийн гэр оронд мөн нийгэмд бие даасан байдлын зарчмыг сурч, хэрэглэснээр бид ядуу зүдүү болон тусламж хэрэгтэй байгаа хүмүүсийг харж хамгаалан, бусдад бие даах чадвартай болоход нь тусалснаар тэд бэрхшээлтэй мөчүүдийг тэвчиж чадах болно.

Бид сүнслэг болон материаллаг байдлын хувьд бие даасан байхын тулд өөрсдийн сонгох эрх чөлөөг ашиглах давуу эрх мөн үүрэг хариуцлагатай. Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Робэрт Д. Хэйлс сүнслэг бие даасан байдал болон Тэнгэрлэг Эцэгт хамааралтай байх талаар: “Бид ариун ёслолоос зөв зохистойгоор хүртэн, ариун сүмийн эрхийн бичиг авахуйц зохистой байж, бусдад үйлчлэхийн тулд золиослол хийн, гэрээндээ залбиралтайгаар амьдарснаар сүнслэг байдлын хувьд бие даасан байдалтай болж, хөрвүүлэгддэг билээ” хэмээн заасан байдаг.²

Ахлагч Хэйлс бидэнд “энэ нь дээд боловсрол эсвэл тусгай мэргэжлийн боловсролтой болох, ажил хийж сурах мөн олсныхоо хэмжээнд зарцуулан амьдрах” зэргээр материаллаг байдлаараа бие даасан

байдалтай болохыг зөвлөсөн. Өрөнд орохоос зайлсхийж, мөнгөө хадгалснаар бид ирээдүйд Сүмийн бүрэн цагийн үйлчлэлд бэлэн байх болно. Бие махбодын болон сүнслэг бие даасан байхын зорилго нь биднийг аюулгүй найдвартай байлган бид тусламж хэрэгтэй байгаа хүмүүст тусалж чадахад оршино.³

Судруудаас

Матай 25:1-13; 1 Тимот 5:8; Алма 34:27–28; Сургаал ба Гэрээ 44:6, 58:26–29, 88:118

Бидний түүхээс

Хожмын Үеийн Гэгээнтнүүд алс бөглүү цөл газар байсан Солт Лэйкийн хөндийд цугларсны дараа Ерөнхийлөгч Бригам Янг тэднээс тогтвортой амьдрах орон гэрээ босгон, хөгжиж дэвшихийг хүссэн. Үүнийг хийхийн тулд Гэгээнтнүүд бие даахад тус болох чадвар, дадлыг сурах хэрэгтэй болсон. Энэхүү хичээл зүтгэлд, Ерөнхийлөгч Бригам Янг эмэгтэйчүүдийн хүчин чадал, авьяас билэг, итгэлтэй байдал мөн бэлэн байдалд нь агуу ихээр найдаж байсан бөгөөд тэрбээр тэдэнд түр хугацааны тодорхой үүрэг хариуцлагуудыг даалгасан юм. Хэдийгээр өнөө үед Нийгмийн Халамжийн бүлгийн эгч нарын хүлээсэн тодорхой үүрэг хариуцлага нь өөр ч гэсэн зарчмууд нь адилхан байдаг билээ:

1. Ажил хөдөлмөрт дурла. Дэмий суухаас зайлсхий.
2. Өөрийгөө золиослох байдлын мөн чанарыг эзэмш.
3. Сүнслэг хүч чадал, эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, санхүү, хоол хүнс болон бусдын амьдралыг тэтгэх хэрэгцээтэй зүйлүүдийг олох өөрийн хувийн үүрэг хариуцлагыг хүлээн зөвшөөр.
4. Сорилтуудыг даван туулах итгэл мөн урам зоригийн төлөө залбир.
5. Тусламж хэрэгтэй байгаа тэдгээр хүмүүсийг хүчирхэгжүүл.⁴

Эшлэл

1. Гарын авлага 2: Сүмийг удирдах нь (2010), 6.1.1.-ийг үзнэ үү.
2. Робэрт Д. Хэйлс “Өөрсдийгөө таньж мэдэх нь: Ариун ёслол, Ариун сүм, Үйлчлэлийн золиослол” *Лиахона* ба *Ensign* 2012 оны 5-р сар, 34.
3. Робэрт Д. Хэйлс, “Өөрсдийгөө таньж мэдэх нь,” 36.
4. *Миний хаант улсын охид: Нийгмийн Халамжийн бүлгийн түүх болон үйл ажиллагаа* (2011), 51-ийг үзнэ үү.

Би юу хийж чадах вэ?

1. Би харж хамгаалдаг эгч нартаа материаллаг болон сүнслэг хэрэгцээний талаар шийдвэр гаргахад нь хэрхэн тусалж байна вэ?
2. Ариун ёслолд бэлтгэж мөн үйлчлэлд өөрийгөө золиосолсноор би өөрийн хүчинд тулгуурлах сүнслэг байдлаа өсгөж байна уу?

© 2013 Intellectual Reserve, Inc. Зохиогчийн эрх батаалгаажсан. АНУ-д хэвлэв. Англи эхийн зөвшөөрөл: 6/13. Орчуулгын зөвшөөрөл: 6/13. *Visiting Teaching Message, September 2013.* Mongolian. 10666 363-ын орчуулга